БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2022/181/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2022 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын<br>дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: кhuanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: У.Ербол<br>Утас: 99425121 Цахим хаяг:erbolu@ audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 3

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 6

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 8

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 10

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 12

3. Аудитын тайлан ........ 14

3.1 Ерөнхий зүйл ........ 14

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 14

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 14

3.4 Материаллаг байдал ........ 15

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 15

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 16

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 17

3.8 Аудитын гол асуудал ........ 17

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 17

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 18

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 18

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 18

4. Аудитын илрүүлэлт ........ 18

4.1 Залруулсан алдаа ........ 18

4.2 Төлбөрийн акт ........ 18

4.3 Албан шаардлага ........ 19

4.4 Зөвлөмж ........ 19

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 19


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2022.02.15 № 47

танай ______ -ны № ______ -т

МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ А. АЙДЫНАСХАР ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **221,418,432.25** | **237,228,130.39** |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | - | 7,200,000.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | - | 7,200,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 221,418,432.25 | 230,028,130.39 |
| **351** | **Түүхий эд материал** | 174,933,698.30 | 186,212,211.44 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 130,133,425.90 | 129,803,065.90 |
| 35130 | Эм боох материал | 44,800,272.40 | 56,409,145.54 |
| **354** | **Хангамжийн материал** | 46,484,733.95 | 43,815,918.95 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 616,615.00 | - |
| 35420 | Аж ахуйн материал | 45,868,118.95 | 43,815,918.95 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **516,498,473.68** | **479,015,085.03** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 516,498,473.68 | 479,015,085.03 |
| **392** | **Биет хөрөнгө** | 514,840,140.21 | 477,356,751.56 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 268,762,200.00 | 268,762,200.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (7,838,897.60) | (12,318,267.68) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 201,342,273.00 | 201,342,273.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (125,432,762.42) | (137,620,314.74) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 351,067,484.74 | 273,492,194.74 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (263,049,737.22) | (203,643,913.50) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 28,755,775.00 | 28,755,775.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (5,780,195.29) | (8,427,195.26) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 67,014,000.00 | 67,014,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,658,333.47 | 1,658,333.47 |
| 39301 | Програм хангамж | 2,280,000.00 | 2,280,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (621,666.53) | (621,666.53) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **737,916,905.93** | **716,243,215.42** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **737,916,905.93** | **716,243,215.42** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 737,916,905.93 | 716,243,215.42 |

| | | | |
|---|---|---|---|
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 651,728,576.52 | 630,054,886.01 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 651,728,576.52 | 651,728,576.52 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (21,673,690.51) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 86,188,329.41 | 86,188,329.41 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **737,916,905.93** | **716,243,215.42** |
| | | 0.00 | 0.00 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,448,885,516.72** | **1,902,732,259.73** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **252,762,013.42** | **523,896,181.73** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 252,762,013.42 | 523,896,181.73 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 252,762,013.42 | 523,896,181.73 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,000,000.00 | 3,000,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 248,762,013.42 | 520,896,181.73 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,196,123,503.30** | **1,378,836,078.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 555,875,200.00 | 744,525,928.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 640,248,303.30 | 634,310,150.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,500,200.00 | 7,177,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 95,713,990.00 | 140,233,950.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 542,034,113.30 | 486,899,200.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,364,719,917.04** | **1,924,405,950.24** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,364,719,917.04** | **1,924,405,950.24** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,352,923,538.04 | 1,872,824,139.05 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 102,652,100.00 | 480,783,391.40 |
| 210101 | Үндсэн цалин | 86,361,300.00 | 378,201,007.40 |
| 210102 | Нэмэгдэл | 12,996,100.00 | 74,938,020.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,294,700.00 | 17,871,200.00 |
| 210104 | Урамшуулал | - | 9,773,164.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 13,858,000.00 | 62,645,189.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 9,751,900.00 | 42,968,939.88 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,026,600.00 | 4,919,162.28 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 821,200.00 | 3,935,349.48 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 205,300.00 | 983,812.80 |

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,053,000.00 | 9,837,924.56 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,599,250.00 | 21,446,793.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,350,000.00 | 1,085,238.00 |
| 210302 | Түлш, халаалт | 18,749,250.00 | 20,000,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,500,000.00 | 361,555.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 35,205,876.00 | 38,844,618.41 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,863,720.00 | 5,769,015.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,712,190.00 | 27,926,860.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,629,966.00 | 4,991,343.41 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,000,000.00 | 157,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 366,900,522.72 | 667,935,058.59 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 364,500,222.72 | 667,935,058.59 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,400,300.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,001,700.00 | 2,500,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 425,800.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 3,575,900.00 | 2,500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,808,200.00 | 9,521,640.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,808,200.00 | 9,521,640.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 762,177,505.00 | 550,526,060.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 760,942,465.00 | 546,259,560.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 521,500.00 | 417,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 149,540.00 | 128,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 164,000.00 | 121,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 400,000.00 | 3,600,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 39,720,384.32 | 38,621,388.65 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 138,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 39,720,384.32 | 38,483,388.65 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 11,796,379.00 | 51,581,811.19 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 995,000.00 | 27,125,728.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 26,633,728.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 995,000.00 | 492,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 10,801,379.00 | 24,456,083.19 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,801,379.00 | 24,456,083.19 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **84,165,599.69** | **(21,673,690.51)** |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **84,165,599.69** | **(21,673,690.51)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 86,188,329.41 | 567,227,906.83 | 653,416,236.24 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 335,070.00 | 335,070.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **86,188,329.41** | **567,562,976.83** | 653,751,306.24 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | 0.00 | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.00 | 0.00 | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 84,165,599.69 | 84,165,599.69 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **86,188,329.41** | **651,728,576.52** | 737,916,905.93 |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **86,188,329.41** | **651,728,576.52** | 737,916,905.93 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **86,188,329.41** | **651,728,576.52** | 737,916,905.93 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | -21,673,690.51 | -21,673,690.51 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **86,188,329.41** | **630,054,886.01** | 716,243,215.42 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,200,123,503.30** | **1,381,836,078.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,000,000.00** | **3,000,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 4,000,000.00 | 3,000,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 4,000,000.00 | 3,000,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,000,000.00 | 3,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,196,123,503.30** | **1,378,836,078.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 555,875,200.00 | 744,525,928.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 555,875,200.00 | 744,525,928.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 640,248,303.30 | 634,310,150.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,500,200.00 | 7,177,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 95,713,990.00 | 140,233,950.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 542,034,113.30 | 486,899,200.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,198,006,953.30** | **1,380,836,078.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,198,006,953.30** | **1,380,836,078.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,186,210,574.30** | **1,329,254,266.81** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 102,652,100.00 | 480,783,391.40 |
| 210101 | Үндсэн цалин | 86,361,300.00 | 378,201,007.40 |
| 210102 | Нэмэгдэл | 12,996,100.00 | 74,938,020.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,294,700.00 | 17,871,200.00 |
| 210104 | Урамшуулал | - | 9,773,164.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 13,858,000.00 | 62,645,189.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 9,751,900.00 | 42,968,939.88 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,026,600.00 | 4,919,162.28 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 821,200.00 | 3,935,349.48 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 205,300.00 | 983,812.80 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,053,000.00 | 9,837,924.56 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,599,250.00 | 21,446,793.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,350,000.00 | 1,085,238.00 |
| 210302 | Түлш, халаалт | 18,749,250.00 | 20,000,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,500,000.00 | 361,555.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 34,150,957.00 | 37,624,003.41 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,808,800.00 | 4,548,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,712,190.00 | 27,926,860.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,629,967.00 | 4,991,343.41 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,000,000.00 | 157,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 236,097,813.30 | 156,736,590.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 235,855,513.30 | 156,494,290.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 242,300.00 | 242,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,015,800.00 | 2,632,600.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,515,800.00 | 132,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,500,000.00 | 2,500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,903,600.00 | 9,521,640.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,903,600.00 | 9,521,640.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 762,777,504.00 | 557,726,060.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 761,542,464.00 | 546,259,560.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 521,500.00 | 417,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 149,540.00 | 128,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 164,000.00 | 121,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 400,000.00 | 10,800,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 155,550.00 | 138,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 155,550.00 | 138,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **11,796,379.00** | **51,581,811.19** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 995,000.00 | 27,125,728.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 26,633,728.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 995,000.00 | 492,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 10,801,379.00 | 24,456,083.19 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,801,379.00 | 24,456,083.19 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **2,116,550.00** | **1,000,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **2,367,500.00** | **1,000,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,367,500.00** | **1,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2,367,500.00 | 1,000,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,367,500.00 | 1,000,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(2,367,500.00)** | **(1,000,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (250,950.00) | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 250,950.00 | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 746,503,000.00 | 723,069,844.81 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 746,503,000.00 | 723,069,844.81 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 717,400,200.00 | 695,944,116.81 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 495,720,400.00 | 480,783,391.40 |
| 210101 | Үндсэн цалин | 390,167,400.00 | 378,201,007.40 |
| 210102 | Нэмэгдэл | 77,678,800.00 | 74,938,020.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 17,874,200.00 | 17,871,200.00 |
| 210104 | Урамшуулал | 10,000,000.00 | 9,773,164.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 68,272,200.00 | 62,645,189.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,043,400.00 | 42,968,939.88 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,057,300.00 | 4,919,162.28 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,045,700.00 | 3,935,349.48 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,011,400.00 | 983,812.80 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,114,400.00 | 9,837,924.56 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,196,600.00 | 21,446,793.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,516,600.00 | 1,085,238.00 |
| 210302 | Түлш, халаалт | 20,000,000.00 | 20,000,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 680,000.00 | 361,555.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 26,484,600.00 | 26,417,043.41 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,548,400.00 | 4,548,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,719,900.00 | 16,719,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,058,900.00 | 4,991,343.41 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 157,400.00 | 157,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 2,516,100.00 | 2,516,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,273,800.00 | 2,273,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 242,300.00 | 242,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,646,600.00 | 3,632,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,014,000.00 | 1,000,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 132,600.00 | 132,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,500,000.00 | 2,500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,600,000.00 | 1,590,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,600,000.00 | 1,590,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 96,825,700.00 | 96,775,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 85,308,500.00 | 85,308,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 417,200.00 | 417,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 128,300.00 | 128,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 131,200.00 | 121,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,800,000.00 | 10,800,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 40,500.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 138,000.00 | 138,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 138,000.00 | 138,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 29,102,800.00 | 27,125,728.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 29,102,800.00 | 27,125,728.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 28,610,800.00 | 26,633,728.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 492,000.00 | 492,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 746,503,000.00 | 723,069,844.81 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 746,503,000.00 | 720,069,844.81 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 746,503,000.00 | 720,069,844.81 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | 3,000,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 3,000,000.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 45 | 44 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 39 | 38 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4 | 4 |
| 620004 | Гэрээт ажилтан | 1 | 1 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **45.0** | **44.0** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 34.00 | 32.00 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 11.00 | 11.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | | 1.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **640,499,253.30** | **634,310,150.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **640,499,253.30** | **634,310,150.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 640,499,253.30 | 634,310,150.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,664,990.00 | 11,206,960.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,664,990.00 | 11,206,960.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 226,581,913.30 | 154,220,490.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 226,581,913.30 | 154,220,490.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,903,600.00 | 7,931,640.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,903,600.00 | 7,931,640.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 400,193,200.00 | 460,951,060.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 400,193,200.00 | 460,951,060.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 155,550.00 | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 155,550.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **640,248,303.30** | **634,310,150.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 640,248,303.30 | 634,310,150.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,500,200.00 | 7,177,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 95,713,990.00 | 140,233,950.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 542,034,113.30 | 486,899,200.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **(250,950.00)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 250,950.00 | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Мал эмнэлгийн газрын  2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын  аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Мал эмнэлгийн газрын  2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжих талаар Монгол Улсын хууль, тогтоомж, олон улсын гэрээ конвенц, аймаг, нийслэлийн ИТХ-ын шийдвэр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, шийдвэр, салбарын ойрын, дунд болон хэтийн бодлого, хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, мэргэжлийн туслалцаагаар холбогдох газрууд болон удирдлагыг хангахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мал эмнэлгийн Ерөнхий  газрын дотоод аудитын хэлтсээс тайлант онд  аудит хийгдсэн байна. Зөрчил дутагдал илрээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1364.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 20.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 15.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Мал эмнэлгийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21.6 сая төгрөгөөр буюу 2.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.00 | 0.00 | 0.00 |
| Авлага | 0.00 | 0.00 | 0.00 |
| Урьдчилгаа | 0.00 | 7200.0 | 7200.0 |
| Бараа материал | 221418.4 | 230028.1 | 8609.7 |
| Үндсэн хөрөнгө | 516498.5 | 479015.1 | -37483.4 |
| **Нийт хөрөнгө** | **737916.9** | **716243.2** | **-21673.7** |
| Өр төлбөр | 0.00 | 0.00 | 0.00 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 737916.9 | 716243.2 | -21673.7 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **737916.9** | **716243.2** | **-21673.7** |

Мөнгөн хөрөнгө, авлагын данс үлдэгдэлгүй байна.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 7.2 сая төгрөг нь open.gov.mn нэгдсэн онлайн платформын үнийг урьдчилж төлсөн зардал байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 23.0 сая төгрөг болж 8.6 сая төгрөгөөр нэмэгджээ. Тайлант онд 196.5 сая төгрөгийн бараа материал худалдан авч, Мал эмнэлгийн Ерөнхий газар, Биокомбинат ТӨХХК, УМЭАЦТөв лабораториас 519.6 сая төгрөгийн эм, боох материал шилжүүлэн авч, 1.2 сая төгрөгийн бараа материалыг /аймгийн ЗДТГ/ үнэ төлбөргүй хүлээн авч, үйл ажиллагаандаа 708.8 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 479.0 сая төгрөг болж 37.5 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 1.0 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 4.2 сая төгрөгийн хөрөнгийг акталж, үндсэн хөрөнгөнд 78.5 сая төгрөгийн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр актласан байна.

Өр төлбөр данс үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 716.2 сая төгрөг болж 21.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 21.6 сая төгрөг буурсантай холбоотой байна.

Мал эмнэлгийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1902.7 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 453.8 сая төгрөгөөр буюу 31.3 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал санхүүжилтийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, нэмэлт санхүүжилтийн орлого байна. Урсгал санхүүжилт өмнөх оноос 188.6 сая , үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 272.1 сая төгрөгөөр нэмэгдэж, нэмэлт санхүүжилтийн орлого 5.9 сая, үндсэн үйл ажиллагааны орлого 1.0 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 559.7 сая төгрөгөөр буюу 41.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал, байр ашиглахтай холбоотой зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал, бусад урсгал шилжүүлгийн зардлууд байна. Цалин, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал , томилолт, зочны зардал, бусад урсгал шилжүүлгийн зардлууд өмнөх оноос нэмэгдэж, байр ашиглахтай холбоотой зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал өмнөх оноос буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Мал эмнэлгийн газрын 2021 оны төсвийг 746.5 сая төгрөгөөр баталсан бөгөөд төсвийн тодотголоор өөрчлөлт ороогүй байна. Нийт зардлын 746.5 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд гүйцэтгэлээр нийт 723.1 сая төгрөг зарцуулж, 24.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Улсын төсвөөс 1.9 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө өгөөгдөөгүй болович 3.0 сая төгрөгийн орлого оруулж төсөвт төвлөрүүлсэн байна.

Цалингийн зардал 14.9 сая, НДШ-ийн зардал 5.6 сая, байр ашиглахтай холбоотой зардал 0.7 сая, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 1.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн ОНХС-аас 486.9 сая, дээд шатны төсвийн захирагчаас 140.2 сая, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 7.2 сая төгрөг, нийт 634.3 сая төгрөг хүлээн авч тарилгын үйлчилгээний хөлс, эм боох материал, цусны дээж цуглуулсан ажилд зарцуулсан тээвэр шатахуун,албан томилолтын зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна. Байгууллага үйл ажиллагаатай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдол гараагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Нийт санхүүжилтийн орлого болох 720.0 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлын 562.6 сая төгрөгийг хасаж үзэхэд 157.4 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 15.7 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байна. Тус газар нь оны эцэст 24.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн тул Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажилласан байна гэж үзлээ.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Мал эмнэлгийн газар нь 2021 онд нийт 746.5 сая төгрөгийн 148 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 746.5 сая төгрөгийн 148 мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн данстай холбоотой 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар зөрчил илрээгүй

**4.1 Залруулсан алдаа**

Байхгүй

**4.2 Төлбөрийн акт**

Байхгүй

### 4.3 Албан шаардлага

Байхгүй

### 4.4 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | |